



IV-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 09




Орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.4 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2021 оны 2 дугаар улиралд 2010 оны эцсээс 79.1 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй, өмнөх улирлаас 0.4 хувиар өссөн байна.


Орон сууцны үнэ 2021 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс Сонгинохайрхан дүүрэгт 3.4 хувь, Баянзүрх дүүрэгт 0.3 хувиар тус тус буурсан байна. Харин Баянгол дүүрэгт 1.1 хувь, Сүхбаатар дүүрэгт 1.0 хувь, Хан-Уул дүүрэгт 0.9 хувь, Чингэлтэй дүүрэгт 0.6 хувиар тус бүр өссөн байна.

Зураг 1: Орон сууцны үнийн индекс, хувиар, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Орон сууцны үнэ 2021 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас Сүхбаатар дүүрэгт 0.7 хувь, Чингэлтэй, Баянгол дүүрэгт 0.6 хувь, Хан-Уул дүүрэгт 0.3 хувь, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт 0.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг 2: Орон сууцны үнийн индекс, хувиар, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээр, өмнөх улиралтай харьцуулснаар



Ойлголт, тодорхойлолт:

Нийтийн орон сууц гэж зориулалтын зураг, төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь дөрөв, түүнээс дээш сууцны зориулалттайгаар төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшинг ойлгоно.

Жин нь нийт сууцны талбайн өртөгт тухайн бүлгийн орон сууцны талбайн өртгийн эзлэх хувь хэмжээ юм.

Тооцох аргачлал:

Орон сууцны үнийн индексийг тооцоход Ласпейресийн хувиргасан индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

энд,

I_{ct}^L – t үеийн с-бүлгийн(агрегатын) Ласпейресийн индекс,

P_{it} - i орон сууцны t тайлант үеийн үнэ,

P_{i0} - i орон сууцны 0 суурь үеийн үнэ,

Q_{i0} – 0 суурь үеийн i төрлийн сууцны өртгийн нийт орон сууцны өртөгт эзлэх хувь

Эх үүсвэр: ҮСХ, Орон сууцны үнийн мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 12

Эдийн засгийн статистикийн газар

дарга Э.Эрдэнэсан

Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газар

шинжээч Б.Оргил

Утас : (976-51)-261561

